



184

# Хөгжлийн Хөтөлбөр Нам

Утас: 9585-3328, 91816126  
E-mail: hhn\_party@chinggl.com

2008 он 05 сар 14 өдөр

№ 03/02

Улаанбаатар хот

## Бага хурлын шийдвэр

УИХ-ын 2008 оны сонгуульд оролцох асуудлаар намын Бага хурал ээлжит хуралдаанаа хийж дараах шийдвэрийг гаргалаа.

1. УИХ-ын 2008 оны сонгуульд нам дангаараа нийт 26-н тойрогт нэр дэвшүүлэн оролцохоор шийдвэрлэсүгэй.
2. Сонгуулийн мөрийн хөтөлбөрийг баталсугай.
3. Сонгууль эрхэлсэн Төв байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг хавсралтаар баталсугай.
4. Сонгуулийн ерөнхий менежерээр намын дарга н. Зууннастыг томилсугай.
5. Сонгуулийн санхүүжилтиг хуулийн дагуу шийдвэрлэхийг санхүүгийн албаны дарга н. Ундрах – д даалгасугай.
6. Сонгуульд оролцох баримт бичгийг хуулийн дагуу бүрдүүлж СЕХ-нд бүртгүүлэх эрхийг намын дарга н. Зууннаст-д олгосугай.
7. Шийдвэр нь батлагдсан өдрөөс хойш хүчинтэй.
8. Шийдвэрийг 3 хувь үйлдэв.
  - нэг хувийг – СЕХороонд
  - нэг хувийг – Намын сонгууль эрхэлсэн Төв байгууллагад
  - нэг хувийг – Намын бичиг хэрэгт

Батлав.

Бага хурлын дарга

Н. Зууннаст

Гишүүд

М. Мөнхнаран

Л. Ундрах


Ч. Адъяахүү

Х. Мөнгөннавч


Д. Ариунболд

М. Гэрэлмаа

Х. Золбаяр



Бага хурал



# Хөгжлийн Хөтөлбөр Нам

Утас: 9585-3328, 91816126,  
E-mail: hhn\_party@chinggis.com

## Хөгжлийн хөтөлбөр намын сонгуулийн мөрийн хөтөлбөр

Иргэдээ баян чинээлэг, өмчлөлтэй болгосноор нийгмийн бусад асуудлыг шийдэх гарц хялбар болно гэж Хөгжлийн хөтөлбөр нам үздэг тул намын бодлогын үндэс суурь үүнд чиглэгддэг. Хөгжлийн хөтөлбөр намын УИХ-ын 2008 оны сонгуулийн мөрийн хөтөлбөр ч энэхүү бодлого зорилтын хүрээнд тодорхойлогдон боловсруулагдсан болно.

### Үндсэн чиглэл

Иргэдээ өмчлөлтэй болгох 3-н цогц зорилтыг хэрэгжүүлэх

- Иргэдийн хөтөлбөр – Хөгжлийн хөтөлбөр
- ХХН-ын багц хөтөлбөрүүд
- “Иргэн бүрт – эзэмшил газар” хөтөлбөр

### Нэг. Иргэдийн хөтөлбөр – Хөгжлийн хөтөлбөр

#### Давуу тал онцлөг


1. Нийгмийн хүсэл сонирхол шаардлагыг бүрэн дүүрэн илэрхийлж чадах цогц бодлого .
2. Иргэдийн хөтөлберийг хэрэгжүүлэх ажиллагаа нь гэрээний үндсэн дээр хуулийн хариуцлагын хэлбэрээр явагдах учир сонгуулийн хийсвэр амлалт болон үлдэх боломжгүй, зайлшгүй хэрэгжих нөхцөл

#### Зорилго чиглэл

1. Төрийн үйл ажиллагаа иргэдийн санаа бодол, хүсэл зоригийн хэм хэмжээнд явагдаж байх, Төрийн үйлчилгээ сонгодог утгаараа Иргэддээ хүрдэг байх үндсэн зорилтыг амьдралд хэвшүүлж , бий болгох зорилготой.
2. Иргэд өөрийн дэвшүүлэн гаргаж буй хөтөлбөртөө дараах зүйлсийг тусгах боломжтой.
  - Төрийн амьдралдаа хэрэгжүүлэхийг хүсч буй жижиг дунд бизнэсийн төсөл
  - Нийгмийн чиглэлийн ажил хэрэгч саналууд
  - Мэргэжил эзэмших ажлын байраар хангагдах, гадаадад сурч ажиллах
  - Орон сууц, ахуйн нөхцөлөөр хангагдах
  - Бусад намуудын сонгуулийн хөтөлбөрөөс өөрт таалагдсан санал санаачилгууд
  - Өнөөгийн төр засгийн явуулж буй бодлого зорилт, хэрэгжүүлж байгаа ажил үүргээс үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж буй бодлого зорилт, ажил үүргийн талаарх өөрийн санал

#### Хэрэгжүүлэх арга зам, шийдэл

1. Иргэдийн дэвшүүлсэн хөтөлберийг хэрэгжүүлэх арга зам шийдлийг ХХН тухай бүрд нь боловсруулан гаргах ба зах зээлийн эдийн засгийн зохицуулалт хууль, ардчилсан нийгмийн үнэт зүйлс зарчимд бүрэн нийцүүлнэ.
2. Иргэн – нам гэсэн хамтын ажиллагааны гэрээгээр хөтөлберийн хэрэгжилт зохицуулагдана.
3. Гэрээнд тусгагдсан хөтөлбөрүүд чиглэл тус бүрээр хэрэгжсэнээр дараа



байнгын хэлбэрээр үргэлжлэн явагдана. Ингэснээр иргэний нийгмийн төлөвшил, залгамж чанар хангагдах нөхцөл бүрэлдэн тогтох юм.

4. Иргэдийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажиллагаа нь хуулийн хариуцлагын хэлбэрээр явагдах учир иргэдээс зөвхөн амьдралд хэрэгжих боломжтой, нийгмийн болоод бусдын эрх ашигт харшлахгүй саналуудыг авч гэрээ байгуулна.
5. Иргэдийн хөтөлбөрийг Хөгжлийн хөтөлбөр намаас нэр дэвших оюуны өндөр чадавхитай доктор, профессоруудын баг хэрэгжүүлэн гүйцэтгэнэ.
6. Иргэд нь хөтөлбөрөө гаргадаг, оюуны чадавхиар илүүтэй нь түүний нь хэрэгжүүлдэг, нам нь хяналтаа тавьж иргэдийнхээ дуу хоопой нь болдог сонгодог тогтолцоо Монголын өнөөгийн нийгмийн хөгжлийн гарц юм.

### **Хөёр. ХХН-ын багц хөтөлбөрүүд**

#### **Давуу тал онцлог**

1. Зах зээлийн эдийн засгийн шударга хуваарилалтын зарчим
2. Хувьчлал нэрээр цөөн тооны хүмүүсийн өмч болох, эсвэл төр **эзэмших** нэрийдлээр нийтийн хөрөнгө болгон үнэгүйдүүлж, төрийн эрх мэдлийг гартаа авсан эрх мэдэлтнүүдийн хууль бус өмч болгохоос **сэргийлсэн** алхам.
3. Иргэдэд хуваарилагдан өмчлөгдсөн багц хувьцааны үнийг **Татварын** бодлогоор Төр эргүүлэн авах шийдэл нь иргэдэд ямарваа нэгэн дарамт, өр үүсэхгүй.

#### **Зорилго, чиглэл**

1. Тэгш хүртээмжтэй шударга зарчмаар иргэдээ эх орныхоо **баялаг**, од хөрөнгийн хууль ёсны бодит өмчлөгчөөр тогтоох, ингэснээр **орлогын** байнгын эх үүсвэртэй болгон, баян чинээлэг нийгмийн үндэс **бүүрийг** бэхжүүлэн тавих зорилготой.
2. Багц хөтөлбөрүүдэд дараах шийдлүүд багтана.

<b>Багц хөтөлбөрүүд</b>	<b>Хувьцаа эзэмших эрх /төрийн мэдлийн/</b>	<b>Лицензийн хувь эзэмших эрх</b>	<b>Бизнесийн үйл ажиллагааны эрх</b>
<b>Багц хөтөлбөр - I</b>	Эрдэнэт үйлдвэрийн хувьцаа Монголын Цахилгаан Холбоо компанийн хувьцаа УБ цахилгаан түгээх сүлжээ компанийн хувьцаа Багануур ХК /нүүрсний уурхай/-ны хувьцаа	Мардайн ураны орд Алтны нийт орд	Төслийн хөрөнгөвөр болон гадаандын бүхий нийт туслах төслийн гүйцэтгэлийн эрх
<b>Багц хөтөлбөр - II</b>	Улаанбаатар Төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэгийн хувьцаа Монросцветмет ХК-ны хувьцаа ДЦС 4 ХК-ны хувьцаа Шивээ овоо ХК-ны хувьцаа	Оюутолгойн орд	Уул уурхийн Байгаль хамгинаан, нийтийн баруун хийж гүйцэтгэх, Байгалийн дагалдах баялаг шинийн тусгийн эрх
<b>Багц хөтөлбөр - III</b>	Эрдмин үйлдвэрийн хувьцаа /Эрдэнэт/ Эрдэнэтийн ДЦС ХК-ны хувьцаа Хөтөл цемент ХК-ны хувьцаа	Таван толгойн орд	Таван толгойн наадмын ордын түүшиглэлийн түүхэндэд түүхэн түүхэн тусгийн эрх
<b>Багц хөтөлбөр - IV</b>	Дарханы хар төмөрлөгийн үйлдвэр ХК-ны хувьцаа— Дарханы ДЦС ХК-ны хувьцаа Багахангайн мах боловсруулах үйлдвэр ХК-ны хувьцаа Шарын гол ХК-ны хувьцаа	Оюутолгойн орд	Казиро Ойнгуулын баялаг
<b>Багц хөтөлбөр - V</b>	Дээрхи багцуудад ороогүй төрийн өмчийт ХК-ны хувьцаа /МИАТ г.м./ Төрийн өмчийн эмнэлэг их дээд сургуулиудын хувьцаа	Таван толгойн орд Бусад ашигт малтмал, өнгөт металлын нийт орд /Асгатын мөнгөний орд г.м./	Дээрхи багцуудад ороогүй төрийн өмчийт ХК-ны хувьцаа /МИАТ г.м./ Төрийн өмчийн эмнэлэг их дээд сургуулиудын хувьцаа

### Гурав. "Иргэн бүрт - эзэмшил газар" хөтөлбөр

1. Иргэн бүр үнэ төлбөргүй газар эзэмших эрхтэй.
2. Энэ эрхийнхээ дагуу иргэн Та өөрийн хүсч буй сонирхсон газраа хуулинд заагдсан нөхцөлөөр эзэмших эрхтэй болох бөгөөд уг газрын үнэ цэн дор дурьдсанаар тодорхойлогдоно.

Газрын хэлбэр	Үнэ цэн
Таны оршин суух газар	Таны оршин суух газар амьдралын баталгаагаар үнэ цэн нь тодорхойлогдоно.
Таны жижиг дунд бизнесийн төсөлд шаардагдах газар	Таны жижиг дунд бизнес эрхлэхэд зайлшгүй шаардагдах үндсэн нөхцөлөөр энэхүү газрын тань үнэ цэн тодорхойлогдоно.
Түрээслэх газар	Тухайн газартай барилга бариулах, үйлдвэр байгуулах, газар тариалан, мал аж ахуй эрхлэх, мөн газар доорхи ашигт малтмалаа олборлуулах зэрэг үйл ажиллагаанд хэн нэгэн этгээдэд ашиглуулсны газрын түрээсийн төлбөрөөр үнэ цэн нь тодорхойлогдоно.

#### Тайлбар, тодруулга:

- a. Та оршин суух газрын хэлбэрийг сонгосноор тухайн газар тань таны амьдралын баталгаа болон Танд үйлчилнэ.
- b. Та жижиг дунд бизнесийнхээ төсөлд шаардагдах газрын хэлбэрийг сонгосноор бизнесээ эрхлэхэд шаардагдах үндсэн нөхцөлөө баталгаажуулна.
- c. Та түрээслүүлэх газрын хэлбэрийг сонгосноор Монгол улсын нутаг дэвсгэрт хувьд өмчлөгдсөнөөс бусад газарт өөрийн газрыг сонгон авч болох бөгөөд Таны сонгож өмчилж авсан уг газарт тань хэн нэгэн хуулийн этгээд ямарваа нэгэн үйл ажиллагаа явуулж буй бол мөн явуулахаар лицөн зөвшөөрөл авсан бол түрээсийн төлбөрийг хуулинд заагдсан хувь хэмжээгээр жил тутам авах эрх үүсч, үүгээр уг газрын тань үнэ цэн тодорхойлогдох юм.

Жишээ нь: Таны өмчилж авсан уг газарт хэн нэгэн этгээд байгалийн баялаг, ашигт малтмал олборлох лиценз авсан мөн олборлолт явуулж байгаа бол танд газрын түрээсийн төлбөрийг хуулийн дагуу төлж явна гэсэн уг. Тухайн этгээд нь төлбөр төлөхөөс зайлсхийвэл Таны шаардлагаар лицензийн эрх нь цуцлагдах зэрэг газрын харилцаагаар зохицуулагдана.

3. Энэ зорилт хэрэгжсэнээр иргэн Таны орлогын бас нэгэн эх үүсвэр эзэмшил газар тань болох бүрэн боломжтой.
4. Энэхүү хөтөлбөртэй холбогдох харилцааг зохицуулах газрын тухай бүрэн хэмжээний багц хуулийг гаргаж хэрэгжүүлнэ.

#### Ач холбогдол

Иргэн бүрт дээрх хэлбэрээр газар өмчлөгдсөнөөр Монгол улсын үндэсний үүлгүй байдал, тусгаар тогтолц тэр хэмжээгээр улам бүр баталгаажиж, газрын үнэ цэн нэмэгдэн, газрыг эргэлтэнд оруулах боломж нээгдэнэ. Иргэн бүрт эзэмшил газар нь үнэт хөрөнгө, орлогын байнгын бодит эх үүсвэр бодж чадна.

Газар бол амьдралын баталгаа орлогын эх үүсвэр хөгжлийн тодорхойлогдоно.



# ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР НАМЫН СОНГУУЛНИЙ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

**Хөгжлийн хөтөлбөр нам** нь УИХ-ын 2008 оны сонгуулийн мэрийн хөтөлбөрөөрөө Монгол улсын иргэн бүртгаах цогц боломж нэхцэлийг санал болгож байна.

- Иргэн бүрээс бие даасан хөтөлбөрийг нь авч хэрэгжүүлнэ.
  - ХХН-с санал болгож буй багц төслийдэд хамруулна.
  - Иргэн бүр газар эзэмших, уг газар нь орлогын бодит эх үүсвэр болж чадах нөхцөлийг бурдуулнэ.

## 1. Иргэдийн хөтөлбөр-Хөгжлийн хөтөлбөр

- Намуудаас дэвшиүүлж буй сонгуулийн хөтөлбөрүүдээс иргэдийн хөтөлбөр нь аль ч талаараа давуутай, нийгмийн хүсэл сонирхол, шаардлагыг бүрэн дүүрэн илэрхийлж чадахуйц цогц болдого болон тодорхойлгдоно.
  - Иргэдийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажиллагаа нь гэрээний үндсэн дээр хуулийн хариуцлагын хэлбэрээр явагдах учир зайлшгүй хэрэгжих бөгөөд сонгуулийн хийсвэр амлалт болон үлдэх боломжгүй, хөтөлбөрийг хэрэгжүүлэхээс зайлсхийх явдал үгүй болох ач холбогдолтой.
  - Иргэдийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажиллагаа нь хуулийн хариуцлагын хэлбэрээр явагдах учир иргэдээс зөвхөн амьдралд хэрэгжих боломжтой, нийгмийн болоод бусдын эрх ашигт харшлахгүй саналуудыг авч гэрээ байгуулна.

Та хөтөлбөртөө дараах зүйлсийг тусгаж болно.  
Өөрийн амьдралдаа хэрэгжүүлэхийг хүсч буй жижиг дунд бизнэсийн төсөл  
чийтийн илрэлтэй

Нийгмийн чиглэлийн саналууд  
Мэргэжил эзэмших, ажлын байраар хангагдах, гадаадад сурч ажиллах  
Олон улсын

Орон сууц, ахуйн нөхцөлөөр хангагдах  
Бусад намуудын сонгуулийн хөтөлбөрөөс өөрт таалагдсан санал санаачилгууд  
Өнөөгийн төр засгийн явуулж буй бодлого зорилт, хэрэгжүүлж байгаа ажил үүргээс ургэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж буй бодлого зорилт, ажил үүргийн талаарх өөрийн санал  
Таны дэвшүүлсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам шийдлийг Хөгжлийн хөтөлбөр нам боловсруулан гаргах ба зах зээлийн эдийн засгийн зохицуулалт, хууль болон ардчилсан нийгмийн үнэт зүйлс, зарчимд бүрэн нийцүүлнэ.

Таны дэвшүүлсэн хөтөлбөрийг Хөгжлийн хөтөлбөр намаас нэр дэвших оюуны өндөр чадавхитай, сэтгэлгээний дээд түвшний доктор, профессоруудын баг хэрэгжүүлэн гүйцэтгэнэ. Иргэд нь хөтөлбөрөө гаргадаг, оюуны чадавхиар илүүтэй нь түүнийг нь хэрэгжүүлдэг, нам нь хяналтаа тавьж иргэдийнхээ дуу хоолой нь болдог сонгодог тогтолцоу Монголын өнөөгийн нийгмийн хөгжлийн гарц юм.

Та хөтөлбөрөө гарга – Хөгжлийн хөтөлбөр нам хэрэгжүүлье

## 2. ХХН-ЫН БАГЦ ХӨТӨЛБӨРҮҮД

Монгол улсын иргэн Таны дэвшиүүлэн гаргасан бие даасан хөтөлбөрөөс гадна дараах багц хөтөлбөрүүдийг цийн хөтөлбөр намаас санаачлан хэрэгжүүлнэ.

И доорхи багц хөтөлбөрүүдээс зөвхөн 1 багц хөтөлбөрт саналаа өгөх ба уг хөтөлбөр дэх үнэ цэнтэй ААН, гийн баялгийн тодорхой хэмжээний хувьцаа эзэмшигч буюу өмчлөгч болж, бодит хөрөнгөтэй болох эх үүсвэр дана.

Ийн өмчлөлд очих сонгосон багц хувьцааны тань үнийг Татварын бодлогоор Төр эргүүлэн авах тул танд  
до Нэгэн дарамт, яр уусахгүй.

Ньчлал нэрээр цөөн тооны хүмүүсийн өмч болох уу, эсвэл төр эзэмших нэрийдлээр нийтийн хөрөнгө болгон шүүлж, төрийн эрх мэдлийг гартаа авсан эрх мэдэлтнүүдийн хууль бус өмч болгох уу, эсвэл нийтэд нь рилалтын зарчмаар хувьчилж, иргэдээ өмчлөлтэй болгох нь дээр үү гэдгийг иргэн Тайлшидэх болно. Иргэн өх орныхоо эд баялгаас өмчөө сонгох эрхийг Хөгжлийн хөтөлбөр нам олгож байна.

Нийгэл үүрүүд	Хувьцаа эзэмших эрх /төрийн мэдлийн/	Лицензийн хувь эзэмших эрх	Бизнесийн үйл ажиллагааны эрх
ИМПОРТБОР - I	Эрдэнэт үйлдвэрийн хувьцаа Монголын Цахилгаан Холбоо компанийн хувьцаа ҮБ цахилгаан түгээх сүлжээ компанийн хувьцаа Багануур ХК /нүүрсний уурхай/-ны хувьцаа	Мардайн ураны орд Алтны нийт орд	Төсвийн хөрөнгөөр болон гадаадын бүхий л зээл тусламжаар хийх төслийн гүйцэтгэлийн эрх
ИМПОРТБОР - II	Улаанбаатар Төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэгийн хувьцаа Монросцветмет ХК-ны хувьцаа ДЦС 4 ХК-ны хувьцаа Шивээ овоо ХК-ны хувьцаа	Оюутолгойн орд	Уул уурхайн байгаль хамгаалал, нөхөн сэргээлт хийж гүйцэтгэх, байгалийн дагалдах баялаг ашиглах тусгай эрх
ИМПОРТБОР - III	Эрдмин үйлдвэрийн хувьцаа /Эрдэнэт/ Эрдэнэтийн ДЦС ХК-ны хувьцаа Хөтөл цемент ХК-ны хувьцаа	Таван толгойн орд	Таван толгойн үйлдвэрлийн ордыг түшиглэсэн ДЦСанд болон шингээ тусламжийн тусгай эрх
ИМПОРТБОР - IV	Дарханы хар төмөрлөгийн үйлдвэр ХК-ны хувьцаа— Дарханы ДЦС ХК-ны хувьцаа		Хөгжлийн үзтэлжээр

<b>Багц хөтөлбөр - V</b>	Дээрхи багцуудад ороогүй териин өмчит ХК-ны хувьцаа /МИАТ г.м./ Териин өмчийн эмнэлэг их дээд сургуулиудын хувьцаа	Таван толгойн орд Бусад ашиг малтмал, өнгөт металлын нийт орд /Асгатын мөнгөний орд г.м./	Дээрхи багцуудад ороогүй өргөй хүрээтэй бизнесийн үйл ажиллагаа бусад эрх Нефть олборлох болон үйлдвэрийн тусгай эрх
--------------------------	---	---	--

### Иргэн баян бол улс баян

#### 3. “Иргэн бүрт - эзэмшил газар” хөтөлбөр

- Иргэн бүр үнэ төлбөргүй газар эзэмших эрхтэй.
- Энэ эрхийнхээ дагуу иргэн Та өөрийн хүсч буй сонирхсон газраа хуулинд заагдсан нохцал эзэмших эрхтэй болох бөгөөд уг газрын үнэ цэн дор дурьдсанаар тодорхойлогдоно.

Газрын хэлбэр	Үнэ цэн
Таны оршин суух газар	Таны оршин суух газар амьдралын баталгаагаар үнэ цэн нь тодорхойлогдоно.
Таны жижиг дунд бизнесийн төсөлд шаардагдах газар	Таны жижиг дунд бизнэс эрхлэхэд зайлшгүй шаардагдах үндсэн нөхцөлөөр газрын тань үнэ цэн тодорхойлогдоно.
Түрээслэх газар	Тухайн газартай барилга барилулах, үйлдвэр байгуулах, газар тариалан, малтмал эрхлэх, мөн газар доорхи ашигт малтмалаа олборлуулах зэрэг үйл ажиллагааны нэгэн этгээдэд ашиглуулсны газрын түрээсийн төлбөрөөр үнэ цэн тодорхойлогдоно.

#### Тайлбар, тодруулга:

- Та оршин суух газрын хэлбэрийг сонгосноор тухайн газар тань таны амьдралын баталгаа болон үйлчилнэ.
- Та жижиг дунд бизнесийнхээ төсөлд шаардагдах газрын хэлбэрийг сонгосноор бизнэсээ эрхлэх шаардагдах үндсэн нөхцөлөө баталгаажуулна.
- Та түрээслүүлэх газрын хэлбэрийг сонгосноор Монгол улсын нутаг дэвсгэрт хувьд өмчлөгдсөнөөр газарт өөрийн газрыг сонгон авч болох бөгөөд Таны сонгож өмчилж авсан уг газарт тань хэн нэгэн үйл ажиллагаа явуулж буй бол мөн явуулахаар лиценз зөвшөөрөл авсан бол түрээслүүлэх төлбөрийг хуулинд заагдсан хувь хэмжээгээр жил тутам авах эрх үүсч, үүгээр уг газрын тань үнэ цэн тодорхойлогдох юм.
- Жишээ нь: Таны өмчилж авсан уг газарт хэн нэгэн этгээд байгалийн баялаг, ашигт малтмал олборлох лиши авсан мөн олборлолт явуулж байгаа бол танд газрын түрээсийн төлбөрийг хуулийн дагуу төлж явигаа түрээслүүлэх төлбөр төлөхөөс зайлсхийвэл Таны шаардлагаар лицензийн эрх нь цуцлагдах зэрэг түрээслүүлэх харилцаагаар зохицуулагдана.
- Энэ зорилт хэрэгжсэнээр иргэн Таны орлогын бас нэгэн эх үүсвэр эзэмшил газар тань болон боломжтой.
- Энэхүү хөтөлбөртэй холбогдох харилцааг зохицуулах газрын тухай бүрэн хэмжээний багц хуулийг түрээслүүлнэ.

#### Ач холбогдол

Иргэн бүрт дээрх хэлбэрээр газар өмчлөгдсөнөөр Монгол улсын үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтолцоог хэмжээгээр улам бүр баталгаажиж, газрын үнэ цэн нэмэгдэн, газрыг эргэлтэнд оруулах боломж нээгдэж. Иргэн бүрт эзэмшил газар нь үнэт хөрөнгө, орлогын байнгын бодит эх үүсвэр болж чадна.

#### Газар бол амьдралын баталгаа орлогын эх үүсвэр.

#### 4. Дүгнэлт

- Та хөтөлбөрөө гаргацтайгаар гараар бичиж ирүүлж болно.
- Та өөрийн дэвшүүлэн гаргаж буй хөтөлбөртөө Хөгжлийн хөтөлбөр намаас санал болгож буй хөтөлбөрүүдээс өөрийн сонгосон багц хөтөлбөрөө, мөн өөрийн сонгосон газар өмчлөх хэлбэрээ түрээслүүлж бичих шаардлагатай.
- Өрхийн дотор байгаа 18 нас хүрээгүй иргэний газар өмчлөх хэлбэрийг эцэг эх, асран хамгаалагч нь тусад нь хийж өөрийн хөтөлбөртөө хавсаргана.
- Таны дэвшүүлэн гаргаж буй хөтөлбөрийг хүлээж авах, албан ёсны гэрээ байгуулах ажиллагаа 2000 түүрээ сарын 9- нөөс 21-ны өдрүүдэд Сүхбаатарын талбайд явагдана.
- Гэрээ байгуулагдсанаар хөтөлбөр хэрэгжих эрх зүйн үндэс хангагдана.
- Та хөтөлбөрөө Сүхбаатарын талбайд ажиллах Хөгжлийн хөтөлбөр намын хэсгүүдэд 2008 оны 08 сарын дотор ирүүлнэ үү. Хөтөлбөрийн доор таны овог нэр, регистр, үнэмлэхний дугаар, хаяг, хүйс, төрлийн байх ёстойг анхаарна уу.
- Гэрээ нотариатаар батлагдах тул иргэний үнэмлэхтэйгээ ирэх шаардлагатай.

Иргэдээ баян чинээлэг, өмчлөлтэй болгосноор нийгмийн бусад асуудлыг шийдэх гарц хялбар болно гэж Хөгжлийн хөтөлбөр нам үздэг тул намын бодлогын үндэс суурь үүнд чиглэгддэг. Иргэдийн хөтөлбөр ч үүнийг батална гэдэгт итгэж байна.